

Ийнхүү монгол, вьетнамын элчин хийгээд соёлын харилцаа, эртний уламжлалтай.

<sup>1</sup> Ngo si Lien, Dai Viet su ky, Toan thu I t 289.

<sup>2</sup> Юан улсын судар. (Гар бичмэл). 209-р дэвтэр

<sup>3</sup>1261 оноос вьетнамын хаан бэлэг сэлт ба алба барьж эхэлсэн бөгөөд Хубилай хаан бичгийн түшмэл, оточ, зурхайч, уран дархцуул тус бүр гутгаарыг алт, мөнгө, шүр сувд, тансаг үнэртэн, зааны соёо, хярсны эвэр, бөс, ваар шаазангийн хамт илгээхийг шаардаж байсан боловч вьетнамын хаан эд юмсыг зааны хамт өгч харин хүн.илгээхийг үл тэвчжээ.

<sup>4</sup> Рашид-Ад-дин. Сборник Литописей. II. том. с. 184

<sup>5</sup> Цагаан түүхэнд «Tügün-u panggyiad» гэж нэр байгаа бөгөөд академич Ш. Бира түүнийг вьетнамтай холбон тайлбарласан буй. Миний бодоход 13-р зуунаас вьетнамтай нягт харилцаж, улсын нэрийг Гяо-жи, Ан нан гэж тов тодорхой бичсээр хэлцсээр ирсэн атлаа « Tügün-u panggyiad» буюу өмнөд хятадын улстай гэнэт хамтатган нэрлэх учиргүй мэт. Цагаан түүхийн тухай «Түүхийн цуврал» УБ., 1967

**МАХН ХЯТАДЫН  
1924—1927 ОНЫ  
ХУВЬСГАЛЫГ ДЭМЖИЖ  
БАЙСАН НЬ**

**Л. Жамсран**

Манай намыг жинхэнэ байгуулсан анхдугаар их хурлаар баталсан намын мөрийн хөтөлбөрт; «...Манай Монгол Ардын Намын эрмэлзэх нь алсдаа монгол үндэстэн бүгдээр нийлж, нэгэн улс болохыг хүснэ. Одоо даруй Хятадын харгис мэдлээс ангижирч, сая мөхсөн автономит Гадаад Монголын төрийг дахин шинэчлэн босгохыг зорино»<sup>1</sup> гэж алдагдсан үндэсний нэгдэл, устгагдсан автономит төрөө дахин босгох тэгэхдээ «шинэчлэн» гэдэг нарийн учиртай санааг хэн бүхэнд ойлгомжтойгоор зорилтоо болгон тодорхойлон заасан юм. Гэхдээ энэ хэргийг гүйцэтгэхийн тул бусад орны ялангуяа хөрш Хятад, Оросын хувьсгалт олон түмэн хийгээд тэдгээрийн намуудтай ажил хэргийн холбоо тогтоож, дэмжлэг тусламж авахыг ихэд чухалчилж байсан тул мөнхүү мөрийн хөтөлбөрт; «Манай Монгол Ардын Намд адил харгисыг халах, боловсролыг урагш давшихыг эрмэлзэх, ард иргэний эрхийг нийтэд тэгшлэн засах хэмээсэн Хятад, Оросын зэрэг гадаад олон улсын хувьсгалчны намууд лугаа нэвтрэлцэн найрамдаж харилцан туслалцахыг хичээнэ»<sup>2</sup> гэж заасан. Ингэж МАХН анх байгуулагдахаасаа эхлэн хятадын харгис хүчийг эсэргүүцэж, хувьсгалт ардчилсан хүчинтэй найрсаг харилцаж, тэдний тус дэмжлэгтэйгээр өмнө тавьсан зорилтоо хэрэгжүүлж, үндэсний тусгаар тогтнолоо байлдан олж, шинэ амьдрал байгуулахын төлөө тэмцсэн юм. Тэгэхдээ 1921 оны гуравдугаар сарын 25-нд Хятадын хувьсгалч хүчинд хандаж гаргасан уриалгадаа: «...дотоод гадаадын харгисуудад нэгэн адил дарлагдан мөлжлөгдөж байгаа хятад, монголын ард түмний эрх ашиг гүнээ ижил тул Монголд цэрэг илгээхээ нэн даруй зогсоохыг МАН-ын Төв Хороо, Монголын

бүх хөдөлмөрчид, сэхээтний өмнөөс Бээжингийн засгийн газарт хатуу шаардахын хамт, Хятадын бүх ард түмэн, түүний хамгийн сайн санаат тэргүүний хэсэгт чин сэтгэлийн нөхөрсөг мэндчилгээ дэвшүүлж, манай шаардлагыг угтан авч засгийнхаа газарт ёс суртахууны болон бусад даралт шахалт, нөлөө үзүүлэхийг»<sup>3</sup> хүссэн байдаг.

МАХН-аас Хятадын хувьсгалт хүчинтэй харьцах үндсэн чиг, түүний анхны баримт бичгүүдэд ингэж томъёологдсон юм.

Ардын хувьсгалын ялалтын дүнд Ар монгол тусгаар тогтнож, ардчилал, нийгмийн дэвшлийн замд ороход Хойт хятадын цэргийн эрхтний засгийн газар хамгаас илүү дайсагнаж байв. Гэтэл хувьсгалт монголын ард түмнээс, Оросын ялгуусан ажилчин, тариачинтай ангийн холбоо тогтоож байлдан олсон төрийн тусгаар тогтнол, нийгэм, эдийн засгийн өөрчлөн байгуулалтаа батлан хамгаалах талаар хийж байсан тууштай алхмууд нь тэдний өнгөлзлөгийг няцаагч хүчин болж байв. Хувьсгалч ардчилсан үзэлтэн Сунь Ятсен тэргүүтэй өмнөт хятадын хувьсгалт засгийн газар, хувьсгалт монгол улсыг дэмжиж байв.

Иймээс монголын хувьсгалыг дэмжигч, хятадын дэвшилт хүчнүүдтэй ажил хэргийн холбоо тогтоож ажиллах явдал МАХН-д чухал шаардагдаж байв. Хятад оронд империализм феодализмыг эсэргүүцсэн хувьсгалт тэмцэл гүнзгийрч байсан нь МАХН-аас хятадын хувьсгалт ардчилсан хүчнүүдтэй харилцах аятай боломж бий болгов. Ялангуяа 1923—1924 онд хятадын улс төрийн гол намууд тухайлбал ХКН, Гомиьндан нам (ГМД)-ууд үндэсний хувьсгалт нэгдмэл фронтод нэгдэж ажиллах болсон үед МАХН тэдэнтэй харилцаж ажил хэргийн холбоо тогтоох тодорхой алхам хийсэн нь цаашид хятадын хувьсгалт нэгдмэл фронттой харилцах үндэс болов. Тэр үед хятад орны ихэнхи хэсэг нь империалист гүрнүүдийн эрхшээлд хагас колонийн байдалтай байв. Иймээс империалистууд өөрсдийн дуулгавартай зарц, хятадын цэргийн эрхтнүүдийг тулгар тогтсон монгол улсын эсрэг тухирч байсан юм.

Байдал нэгэнт ийм байсан болохоор империализм, хятадын нийт харгис хүчний эсрэг тэнд гарч байгаа хувьсгалт тэмцлийг дэмжиж, туслах явдал МАХН-д юу юунаас чухал байв. 1924 оны зун МАХН-ын III их хурал хуралдаж, тус намаас хятад болон дорнодахины бусад орнуудын хувьсгалт нам, хувьсгалч олон түмэнтэй хэрхэн харилцах чиг шугамыг зааж өгөв. Намын III их хурлаас заахдаа: «Бүх дэлхийн олон улсын эв хамтын намууд ба ялангуяа Алс Дорно дахь хятад японы эсрэг улсын Ардын нам ба Эв хамт нам лугаа хэлхээ холбоо байгуулан харилцан явалцаж, холбогдлыг зузаатгахыг Төв Хорооноос эрхлэн гүйцэтгэвэл зохино»<sup>4</sup> «...бүх хувьсгалчдын зорилго бол хятад орон, хятадын хөдөлмөрчдийг эдгээр араатны (империализм, хятадын цэргийн эрхтний -Л.Ж.) эрх мэдлээс ангижруулж, бүх хүн төрөлхтнийг чөлөөлөхийн төлөө аугаа их тэмцэлд манай жинхэнэ хань холбоотон болгоход оршино»<sup>5</sup> гэжээ.

Хятадад үлэмжхэн далайцтай өрнөж байгаа хувьсгалт тэмцлийг МАХН ийм чиг баримжаатай угтсан юм.

Хятад оронд хувьсгалт тэмцэл хүчтэй өрнөж, олон түмний дунд хувьсгалт нэгдсэн фронтын нөлөө мэдэгдэхүйц өсч Гуанчжоу дахь хувьсгалын бааз улам бүр бэхжиж байв. Тэгэхэд империализм ба хятадын харгис хүчнүүд Сунь Ятсений хувьсгалт засгийн газрыг түлхэн унагах гэсэн оролдлогоо орхихгүй идэвхжүүлж байлаа. Тийм үед ГМД Намын нэр хүндтэй удирдагч, өмнөд хятадын хувьсгалын бааз Гуандунгийн засгийн газрын тэргүүн, хувьсгалч ардчилсан үзэлтэн Сунь Ятсен 1925 оны 3-р сарын 12-нд зуурдаар нас барав. ГМД намын Төвийн Гүйцэтгэх Хороо Сун Ятсен нас барсныг тэр өдөр нь МАХН-

ын ТХ-нд цахилгаан утсаар мэдэгдсэнд МАХН-ын ТХ эмгэнэл илэрхийлсэн цахилгаан утас явуулснаас гадна Сунь Ятсенийг оршуулах ёслолд оролцох төлөөлөгчид томилов. Уг төлөөлөгчид Сунь Ятсенийг сүүлчийн замд нь үдэх ёслолд оролцохын зэрэгцээ хятадын хувьсгалт нэгдмэл фронтод багтдаг байгууллагуудын эрх баригчид болон Фэн Юйсянтай уулзаж ажил хэргийн холбоог бататгах зорилготой ажээ. Иймээс МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн, Гадаад Явдлын яамны сайд А. Амар тэргүүтэй намын төлөөлөгчдийг\* хятадад явуулсан байна.<sup>6</sup> МАХН-ын төлөөлөгч Сунь Ятсенийг оршуулах ёслолд оролцсоноос гадна Бээжин дэх ГМДН-ын засгийн явдлын комиссын олон гишүүдтэй уулзаж тус хоёр намын харилцааны асуудлыг хэлэлцсэн байна. Хэлэлцээний дүнд МАХН, ГМДН-ын харилцааны тухай дөрвөн зүйлийг 4-р сарын 26-ны өдөр хэлэлцэн тохиролцсон:

Үүнд: 1. Хоёр улсын ардын нам<sup>2</sup> Сун Чжуншань<sup>3</sup> авгайн ард угсаа өөрөө таслах зорилгыг (үндэстний өөрөө засан тохинох эрх -Л.Ж.) журамлан явна.

2. Хоёр улсын ардын намаас өөр өөрийн зорилго суртлыг дэлгэрүүлнэ.

3. Хоёр улсын ардын намаас харилцан төлөөлөгч томилно.

4. Хоёр улсын ардын нам хэрэг тохиолдвоос харилцан туслалцана гэжээ.<sup>7</sup> Намын төлөөлөгчид ийнхүү хэлэлцээ хийж байх үеэр Фэн Юйсян тус төлөөлөгчдийн тэргүүн А. Амарт бичсэн нэг захидалдаа: «Хоёр этгээдийн холбоо тогтоохыг үлгэрлэвэл цэргийн зэвсэг нэвтрүүлэх, тэмээ, морьдыг олноор худалдан авах, туслан олгох зүйл зүйлийн худалдааны явдлын харилцан нэвтрэлцэх их хэрэгт цөм өөр өөрийн хүчээр туслалцаж...хятад монгол хоёр угсаатны хоорондох холбогдлыг найрамдлаар таслахыг гол болгох, цэргийн хүчээр үзэлцэж гар хөл эрхтнээ гэмтээхийг татгалзана. Ялангуяа хоёр этгээд гар гараа барилцаж ард угсаатны эрх тэгш болох явдлыг илрүүлэхийг шаардуулан бүтээхийг хүснэ»<sup>8</sup> гэж уулзаж хэлэлцээ хийхийн өмнө мэдэгдсэн байна. Дараа нь Фэн Юйсян МАХН-ын төлөөлөгчидтэй уулзаж хэлэлцээ хийхдээ БНМАУ-ыг тусгаар тогтносон улс гэхээс татгалзаж байв.

МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчид 1925 оны 5-р сарын шинэдээр хятадад явсан намын төлөөлөгчдийн илтгэлийг сонсч хэлэлцээд ГМД намтай харилцах зарчим, Фэн Юйсянд туслах арга хэмжээний тухай тогтоол гаргасан ажээ. Түүнд заахдаа: ГМД намаар монгол улсыг зөвшөөрүүлэх, түүнийг Монгол улсын дотоод хэрэгт үл оролцуулахаас гадна, монголын хязгаарт цэрэг түлхэн оруулахгүй байх, тэрчлэн монгол улсын дайсан этгээдтэй гэрээ холбоо байгуулахгүй байлгахгаас гадна Дотоод монгол, Барга, Тарвагатайн зэрэг газрын монголчуудад автономит эрх олгуулах, тэдгээрийн ардын эрхийг хүндэтгэн үзэж, үндэс угсаанд харштай хэргийг үл явуулах, мөнхүү газраа ардын намын явдлыг бүрэн бүтнээр гүйцэтгэж явуулах эрх олгох. Фэн Юйсян хятадын засгийн эрхийг авмагцаа Өвөр Монгол зэрэг өөр угсаатанд өөрөө засан тохинох эрх олгохыг зөвшөөрвөл гэрээ байгуулж болно гэж үзсэнээс гадна Фэн Юйсяны хүсэлтийн тухай заахдаа: Монгол улсаас Фэн Юйсяны аливаа хэрэгт тустай санаа тавьж байх, тус улсын нутаг дээгүүр зэр зэвсэг нэвтрүүлэх. Хэрэв чухал хэрэг тохиолдвол тус улсаас албан газраар уламжлан морь худалдан авч байх, орос,

1- Төлөөлөгчдийн бүрэлдүүнд Гэлэгсэнгэ, Навааннэрэн, Хасагбай нар оролцжээ.

2 -- Тэр үед Гоминьданы намыг ардын нам гэж монгол хэлнээ орчуулж байжээ.

3- Сунь Ятсен (1866-1925)-ий нэг нэр. Түүнийг бас Сун Исянь, Сун Вэнь гэдэг.

хятад, монгол гурван этгээдээс автомашинаар тээвэр хийх, хоршоо байгуулах, монгол улсаас Фэн Юйсянд туслах цэрэг гаргахгүй, мөн түүний дайсан этгээд тус улсын нутаг дээр хүч хуримтлуулахыг зөвшөөрөхгүй байвал зохино<sup>9</sup> гэсэн байна.

1925 оны 5-р сарын 16-ны өдөр хуралдсан МАХН-ын ТХ-ны Тэргүүлэгчдийн 25-р хурал тус намаас ГМД Намын газар суух төлөөлөгчид олгох 10 зүйл бүхий зааврыг хэлэлцэж батлаад<sup>10</sup> мөн сарын 19-нд хуралдсан 26-р хурлаар ГМД намын газар суух МАХН-ын төлөөлөгчөөр Г. Гүрсэдийг баталсан ажээ.

МАХН-ын төлөөлөгч Хятад улсад ийнхүү явахаар бэлтгэж байх үед Фэн Юйсяны цэргийн штабын дарга Чжан гэгч БНМАУ-ын засгийн газарт хандаж: зэвсэг ачих авто машин, мөн тэрэг сэлбэх багаж хэрэгсэл ба Хар мөрөн мужийн түүгээр Чжан Цзолинтай байлдах нэгэн анги цэрэг туслах, харилцан төлөөлөгч суулгах гэх зэрэг хүсэлт тавив. Түүнийг МАХН-ын ТХ-ны Тэргүүлэгчид 1925 оны 6-р сарын 4 ний 31-р хурлаараа хэлэлцэж, зэвсэг ачих, авто машин, сэлбэг хэрэгслийг хөлсөөр олж туслах цэргээр туслахыг үл хэрэгсэх, харилцан төлөөлөгч суулгахыг зөвшөөрвөл зохино гэсэн шийдвэр гаргасан ажээ.<sup>11</sup>

1925 оны 5-р сарын 30-нд ХКН-ын уриалгаар Шанхайн оюутнууд империализмыг эсэргүүцсэн сүрт жагсаал хийхэд Англи, Америкийн харгис цагдаа нар гал нээж 10 гаруй хүн алж олон хүн шархдуулснаас гадна сүрт жагсаалд идэвхтэй оролцогчдыг баривчилсан байна. 5-р сарын 30-ны хөдөлгөөний үед тариачид тэмцэлд боссонгүй. Хувьсгалыг империалистууд, цэргийн эрхтний нэгдсэн хүч эсэргүүцэж, хятадын том хөрөнгөтний дэмжлэгийг олоод 6-р сарын сүүлч болоход пролетари нараас Шанхайн дунд ба жижиг хөрөнгөтнүүдийг хөндийрүүлэн гол цохилтоо пролетари нар руу хандуулсан байна. Яг энэ үеэр МАХН-ын төлөөлөгч Г.Гүрсэд 6-р сарын 16-нд Бээжинд хүрэлцэн очиж үүрэгт ажлаа эхэлсэн юм. Англи, Японы түрэмгийллийг эсэргүүцэж буй хятад ажилчин, оюутан залуучуудад Гүрсэд өөрийн намын нэрийн өмнөөс 1000 янчаан тусалсан<sup>12</sup> бөгөөд Япон, Герман, Энэтхэгийн хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн хамт, харгис цагдаагийн дарангуйлалд хэлмэгдсэн хятад ажилчидтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн ажээ. МАХН-ын төлөөлөгч нь ХКН-ын ТХ-ны гишүүн, ХКН-ын Умартын товчооны нарийн бичгийн дарга, Бүх Хятадын ажилчдын нарийн бичгийн дарга нарын газрын Умартын салбарын эрхлэгч коммунист Ли Дачжаотай уулзаж хятад орны байдал, хувьсгалын өрнөлттэй танилцахын ялдамд монголын тусгаар тогтнолыг хэрхэн үзэж буйг лавласанд Ли Дачжао: «Монгол угсаатны тусгаарлах ба бас ард угсаа өөрсдөө таслах гэсэн бүрэн эрхийг зөвшөөрөх хэрэгтэй» гэж үзэж байгаагаа илэрхийлээд энэ талаар «Гуандунгийн засгийн газрын удирдагчдын санал, зөвшөөрлийг хүлээж буй»<sup>13</sup> хэмээн мэдэгдсэн. Ли Дачжао мөн яриандаа монгол улс империализмын эсрэг хятадын болон дэлхийн хувьсгалын явцад их тус болж байгааг цохон тэмдэглэж байжээ. МАХН-ын төлөөлөгч Г. Гүрсэд Бээжинд буй, ГМД намын засгийн явдлын комисстой 6 сард хэлэлцээ хийж МАХН-ын түрүүчийн төлөөлөгч А. Амарын хэлэлцэн тохирсон 4 зүйлийг дахин тодотгож нарийвчлан хэлэлцэж тохиролцсон байна. Үүнд «Нэгдүгээр зүйл, Дундат улсын Ардын Нам болбоос Дундат улсын олон ард угсаатан бүхийг цөм ард угсаатан өөрийн дур саналаар болох зорилтыг барьж, ард угсаатан эрх чөлөөгөө олно хэмээн оролдон буй үйлсэд туслаж...монгол угсаатныг болбоос түүний эрх чөлөө олох явдлыг бүрнээ эрхэмлэн хүндэтгэнэ. Гагцхүү Дундат Улсын Ардын Намаас туйлаар хүсэх болбоос: Дундад улсын ард уг-

саатан монголын ард угсаатантай туйлын янаг ах дүүгийн найрамдал ба холбоог байгуулахыг хүснэ. Иймийн тул Дундат улсын хувьсгалын явдал бүтсэний хойно хоёр ард угсаатны ашиг тус, тэгш болсоны үеэс, хоёр ард угсаатан өөр өөрийн дур санаагаар эрх тэгш холбоотой болохыг эрмэлзжээ. Эдүгээгээс эхлэн дэлгэрүүлэн оролдох энэхүү зорилтыг эцэст хүргэж бүрнээ бүтээхийг зорино.

**Хоёрдугаар зүйл:** Дундат улсын ардын нам өөрийн намын гишүүн ба ард түмэндээ монголын хувьсгалт ардын ёс журам ба зорилт хийгээд засгийн байдлыг ухуулан танилцуулна. МАХН түүний намын гишүүд ба ард түмэндээ Дундат улсын ардын намын зорилт ба суртал хийгээд Дундат улсын ард угсаатны жинхэнэ ардын саналыг танилцуулна.

**Гуравдугаар зүйл:** Хоёр нам эдүгээгээс эхлэн харилцан төлөөлөгч томилж МАХН-ын ТХ-ны төлөөлөгч Гуанчжоу буюу Бээжинд сууна. Дундат улсын Ардын намын төлөөлөгч болбоос Улаанбаатар хотноо сууна.

**Дөрөвдүгээр зүйл:** Дундат улсын аль нэгэн этгээд ба бус өөр дайсан этгээдээс монголд халдаар орох буюу хорлох аваас Дундат улсын Ардын Нам зүй нь ард түмэндээ ухуулж «дарлагдана» хэмээгч нэгэн адил хэмээн мэдүүлнэ. Хэрэв Дундат Улсын Ардын Намын этгээдэд ийнхүү явдал тохиолдвоос Монгол Ардын Нам мөн л нэгэн адил ийм үүрэг хүлээнэ»<sup>14</sup> гэж уг баримт бичигт заажээ.

Үүнээс үзэхэд МАХН нь хятадад өрнөж буй үндэсний хувьсгалыг дэмжихийн хамт ГМД-аас үндэстний асуудлын талаар баримтлаж буй зорилтыг хятадын харьяан дахь хятад бус угсаатны хувьд хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих, тэгснээрээ монголын тусгаар тогтнолыг ГМД хятадын хувьсгалт засгийн газраар албан ёсоор зөвшөөрүүлэх, нөгөө талаар хятадын харгис этгээдээс монгол улсруу хийж болзошгүй халдлагыг ГМД ба хятадын ард түмнээр сэрэмжлүүлэхэд их анхаарсан нь илэрхий.

Гуанчжоу дахь ГМДН-ын ТГХ нь МАХН-ын төлөөлөгч ба ГМД намаас Бээжинд суугаа засгийн явдлын комиссоос хэлэлцэн тохирч боловсруулсан дөрвөн зүйлийн саналыг бүрэн зөвшөөрсөн боловч гарын үсэг зурах явдлыг тус намын хувьсгалт цэрэг эсэргүүцэгчдийг дарж төвшин болсон үед МАХН-ын төлөөлөгчийг Гуанчжоу хотноо урьж гүйцэтгэе гэж хариу ирүүлсэн ажээ<sup>15</sup>.

МАХН-ын төлөөлөгчтэй Фэн Юйсян биечлэн уулзаж, хятад, БНМАУ, ЗХУ хамтарч автомашины хоршоо даруй байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Тэр үед тийм хоршоо байгуулах нь юуны урьд империализмын эсрэг хятадын ард түмний хийж буй тэмцлийг ЗХУ, БНМАУ-аас дэмжиж туслах, худалдаа хийхэд их дөхөм болох байв.<sup>16</sup>

5-р сарын 30-ны хэрэг явдлаар эхлэсэн хятадын хувьсгалыг тус орны янз бүрийн нутагт ард олон дэмжиж тэмцлийн эгнээнд элсч орсоор байв. Ажилчин, тариачны тэмцлийн зохион байгуулалт өсч, хятадын өмнөт нутагт хувьсгалын бааз бэхжсээр байв. Хувьсгалын бааз нутагт ГМД ба олон түмний дотор ХКН-ын нөлөө их өсч байлаа. Гэтэл Төв ба Хойт хятадын ажилчны хөдөлгөөний дотор бат суурьтай болоогүй байсан учраас ХКН ажилчин ангийн олон нийтийн томхон тэмцэл зохион байгуулж чадахгүй байв.

Империализмыг эсэргүүцсэн үндэсний хувьсгал хятадад эхлэхийн хамт ГМД-ы буюу Гуандунгийн засгийн газар нь хойт хятадын цэргийн эрхтний захиргааг түлхэн унагаж бүх хятадыг хяналтдаа нэгтгэх

явдлыг өөрийн зорилт гэж зарлаад 1925 оны 7-р сарын 1-нд өөрийгөө Дундат Иргэн улсын үндэсний засгийн газар гэж албан ёсоор тунхаглав. Түүнчлэн хувьсгалд оролцогч цэргүүдийг нэгтгэн үндэсний хувьсгалт цэрэг (ҮХЦ) хэмээн нэрлэв.<sup>17</sup> Энэ бол хятадын хувьсгалын явцад гарсан том давшилт мөн. Үүнд дэлхийн ууган социалист гүрэн ЗХУ-ын интернационалч тусламж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэвэл зохино. Сун Ятсений хүсэлтээр 1923 оноос зөвлөлтийн улс төр, цэргийн зөвлөгчид өмнөд хятадад ирж, хятадын улс төрийн гол намууд болох ГМД, ХКН-ыг империализмын эсрэг хувьсгалт нэгдмэл фронтын байгууллага болгож хувиргах, үндэсний хувьсгалт цэргийг бий болгох, Гуандун муж дахь хувьсгалын баазыг бэхжүүлэх зэрэг ажилд оролцсон билээ. Тэр үед ЗХУ хүнд бэрхшээлтэй байлаа ч гэсэн хятадын хувьсгалт олон түмнийг дэмжихээс татгалзаагүй юм. Хятадад хувьсгалт тэмцэл өрнөж байхад хятадын ард түмэнд туслах явдал зөвлөлтийн Алс Дорнодын бодлогод зонхилох суурь эзлэж байжээ.<sup>18</sup> Зөвлөлтийн цэргийн зөвлөгчид, хятадын коммунистууд ҮХЦ-ийн байлдааны чадварыг дээшлүүлэх талаар их чармайн ажилласны дүнд ҮХЦ 1925 оны эцсээр Гуандун мужийн нутгаас хятадын цэргийн эрхтний цэргийг цохин зайлуулж, үндэсний засгийн газрыг их бэхжүүлсэн юм.

Хятадад империализмыг эсэргүүцсэн хувьсгалт тэмцэл амжилттай өрнөж байгаа явдалд БНМАУ-ын хөдөлмөрчид гүн талархаж байв. Иймээс хятадын хувьсгалыг дэмжих хөдөлгөөн өрнөж «Хятадын хувьсгал мандтугай» империалистууд «хятадаас авраа татагун»<sup>19</sup> гэсэн уриа шаардлага хот хөдөөгүй цууриатаж байлаа. 1925 оны 7-р сарын 2-нд Улаанбаатар хотноо олон нийтийн томхон цуглаан болж тэмцэж байгаа хятадын ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй байж, империализмыг эсэргүүцсэн хувьсгал ялалтад хүрнэ гэдэгт бат итгэж байгаагаа илэрхийлсэн байна.<sup>20</sup> Мөн онд МАХН, МҮЭ-ийн дэмжлэгээр БНМАУ дахь хятадын харьяат нарын дунд үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулагдаж, хятадын хувьсгалыг дэмжиж, туслах ажлыг хятадын харьяат нарын дотор зохиох болсон байна.<sup>21</sup>

Тэр үед хойт хятадад Фэн Юйсяний үндэсний цэргийн ажиллагаа ихээхэн идэвхжив. 1925 оны 9-р сард Чуулалт хаалга хотод гурван этгээдийн хэлэлцээ хийж автомашины хоршоо байгуулах хэлэлцээрт гарын үсэг зурж уг хэлэлцээрийн дагуу 1925 оны 11-р сард Улаанбаатар-Чуулалт хаалга, Улаанбаатар-Дээд Үдийн хооронд автомашины байнгын тээврийн ажиллагаа нээсэн ажээ.<sup>22</sup> 1925 оны намар Фэн Юйсян, Чжан Цзолинтэй байлдаж амжилттай давшсаар 11-р сарын 26-нд Бээжинг эзлэж мөн сарын сүүлчээр Тяньцзин руу хөдөлсөн байна, Бээжинд оюутан ажилчин сэхээтний сүрт жагсаал, цуглаан болж Японы талыг барьсан Дуань Цижуйн засгийн газрыг огцруулахыг шаардахын зэрэгцээгээр хятадад ардын засгийн газар байгуулахыг Фэн Юйсянд уриалж байх болов. Олон түмний эл тэмцлийг Ли Дачжао тэргүүтэй ХКН-ын умартын товчоо удирдаж байв. Гэвч Фэн Юйсян гуйвж, империалист гүрнүүд өмгөөлсний ачаар Дуань Цижуй засгийн эрхэндээ үлдсэн юм. 1926 оны 2-р сард цэргийн эрхтэн Чжан Цзолин У Пэйфу нар эвлэрч Фэн Юйсяний үндэсний цэргийн эсрэг хамтран давшсан ажээ. Тэр үеэр 3-р сарын 12-нд япон цэргийн хөлөг онгоц Тяньцзингийн ойр байсан үндэсний цэргийн ангиудруу гал нээв. Япон, Англи, АНУ, Франц, Итали болон бусад орны төлөөлөгчид Фэн Юйсянийг Тяньцзин Бээжингийн хавиас зайлахыг тулган шаардсан. Тиймээс Шэньси, Ганьсу Суйюань, Цахар мужууд руу ухарч хориглолтын байдалд орсон ажээ. Тэгэхэд Фэн Юйсяний арми 120-130 мянган хүнтэй байв. Фронтын шугам нь 250 км урт байжээ.

Үндэсний цэргийн байдал хүндэрсэн үед түүний ерөнхий захирагч Фэн Юйсян 3-р сард ЗХУ-д очиж суралцахаар явах замдаа БНМАУ-д сар гаруй хугацаагаар байв. Тэр 1944 онд хэвлүүлсэн «Миний амьдрал» гэдэг дурдатгал зохиолдоо монгол, зөвлөлтөд байсныгаа нэлээд тодорхой дурьдсан байдаг. МАХН-ын ТХ түүнийг хүндэтгэн хүлээж авсаныг дурьдаад: «Энэ удаа би монголд 30 гаруй хоног байхдаа намын ажил болон орос хэл сурахаас гадна монголын улс төр, нийгмийн олон талыг судлах ажил хийв. Надад сэтгэгдэл болж үлдсэн зүйл гэвэл: Улс төрийн талаар. Нэг нам төрийг удирдаж байна. Би тэдний намын дарга болон ТХ-ны гишүүдтэй дотно харьцаж байв. Тэд ерөнхийдөө цөм цовоолог бөгөөд улс төрийн ажлыг чармайн хийдэг сэргэлэн хүмүүс байв. Намайг нэг удаа нам засгийн хамтарсан хуралдаанд урьж суулгав...Бүтээн байгуулалтын талаар засгийн газар нь нэлээн амжилт олж байна. Байшин барилгын талаар гэхэд л Манж Цин улс нь монголыг хэдэн зуун жил ноёрхохдоо ардыг мунхруулах, хэдэн сүм хийд, хэдэн жижиг харанхуй байшингаас өөр барьсан зүйл алга байна. МАН төрийг удирдах болсноос хойш богино хугацаанд ардын төлөө хүрэлцээтэй модон байшин бариулсан байна.»<sup>23</sup> гэх зэргээр манай шинэ нийгмийн байгууллыг талархаж бичсэн байдаг. Гэхдээ БНМАУ-ыг хятадын хэсэг гэж үзэж байсан нь түүний «миний бодоход хятадын үндэстнүүд бүхэл бүтэн байх ёстой. Ингэж саланги байдалтай удаан байх нь харамсалтай байна.»<sup>24</sup> гэж бичсэнээс илэрхий. Тэр манай улсын удирдах хүмүүсээс «Танай тусгаар тогтнолыг устгаж болох уу-» гэж асуухад тэд хариулахдаа: «Тусгаар тогтнолыг устгаж болно. Тэгэхдээ хятадад жинхэнэ ардын засгийн газар буй болсон цагт л болох юм»<sup>25</sup> гэж хятадын ард түмний хувьсгалт тэмцлийг дэмжих тактикийн үүднээс хандсан ажээ. Фэн Юйсян Улаанбаатарт байхдаа Коминтерны төлөөлөгч, ЗХУ-ын элчин төлөөлөгч нартай удаа дараа уулзаж коммунист интернационалын үйл ажиллагаа, зөвлөлт байгуулал болон зөвлөлтийн гадаад дотоод бодлого тэргүүтнийг сайн мэдэж авсан байна.

МАХН хятадын хувьсгалыг дэмжиж ГМД намтай харилцаатай ажиллаж байсан цаг тул Фэн Юйсянийг Улаанбаатарт байхад ГМД намын хэсэг зүтгэлтэн ажлаар ирээд Фэн Юйсянд намынхаа бодлогыг сайтар ухуулан түүнийг ГМД намд элсүүлсэн ажээ.<sup>26</sup>

1926 оны хавар үндэсний цэрэг ялагдаж ухарсан нь хойт хятад дахь олон түмний хөдөлгөөнийг дарагдалд хүргэв. 1926 оны 3-р сарын 18-нд Бээжинд империализмыг эсэргүүцсэн олон нийтийн сүрт жагсаалыг харгис хүчин буудсан явдал бол хувьсгалын эсрэг дайралтын дохио болов.

1926 оны хавар Гуандунгаас гадна Гуанси, Гуйчжоу болон Хунань мужийн хагас нь үндэсний засгийн газрын хяналтанд байв. 1926 оны 3-р сарын 20-нд Чанкайши, түүний удирдсан бүлэглэл ХКН-ын нөлөөг сулруулах ажилчин тариачны хөдөлгөөнийг тасалдуулахын тулд Гуанчжоуд эргэлт хийж ГМДН-ын ТГХ-ны дарга, үндэсний засгийн газрын цэргийн зөвлөлийн дарга тус тус болсон байна. 5-р сард ГМДН ын ТГХ-ны бүгд хурал болж ГМД-ы дотор коммунистууд гүйцэтгэх үүргийг хязгаарлах, Гоминьданы төв байгууллагад коммунистууд удирдах тушаалд ажиллахыг хориглох шийдвэр гаргасан байна. Мөн бүгд хурлаас умарт мужуудын цэргийн эрхтнүүдийн эсрэг аян дайн эхлэх шийдвэр гаргаж аян дайнд оролцох бүх цэргийн ерөнхий захирагчаар Чан Кайшийг батлав.

Гуанчжоугийн үндэсний засгийн газар 1926 оны 7-р сарын 1-нд Умартын аян дайны тухай тунхаг гаргаж ҮХЦ-ийн гол хүч умарт зүг

улс орноо нэгтгэж ардчилахын тул хөдлөв. Цэргийн эрхтнүүдийн эсрэг умартын аян дайн хийх явдлыг Сунь Ятсен ГМДН-ын улс төрийн үндсэн зорилт болгож анх дэвшүүлсэн билээ. Умартын аян дайныг хэрхэн үзэх явдал ХКН-ын тактикийн нэгэн зангилаа асуудал байлаа. Иймээс 1926 оны 7-р сарын эхээр ХКН-ын ТХ-ны бүгд хурал болж Умартын аян дайныг «гадаадын империалистүүд ба дотоодын цэргийн эрхтний дарлалыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинэ үе» гэж үнэлээд аян дайны үед ажилчин тариачны хөдөлгөөнийг өргөжүүлэх тактик хэрэглэхээр шийдэж янз бүрийн ангийн хувьсгалт олон түмнийг хувьсгалт нэгдмэл фронтоо бэхжүүлэн дотоодын цэргийн эрхтнийг түлхэн унагаж, империализмд цохилт өгөхийг уриалсан байна.<sup>27</sup>

1926 оны хаврын байдлаар Гоминьданы үндэсний засгийн газрын хяналтад байгаа 4 мужийн цэрэг буюу ҮХЦ нь 100 мянга орчим хүнтэй байлаа. Түүний цэргийн холбоотон нь түр ялагдаж баруун тийш ухран үлдсэн хүчээ хадгалж байсан Фэн Юйсяний үндэсний цэрэг байв. Тэр нь бас зуу мянга гаруй хүнтэй байв. ҮХЦ-ийг ажилчин тариачин, олон нийтийн байгууллага ХКН идэвхжтэй дэмжиж байснаас гадна тус орны бүх дэвшилт хүчин талархаж байв. ҮХЦ ба үндэсний цэргийн аль алинд зөвлөлтийн цэргийн зөвлөгчүүд ажиллаж байсан бөгөөд умартын аян дайны цэрэг стратегийн төлөвлөгөөг нэрт жанжин В.К. Блюхер тэргүүтэй цэргийн зөвлөгч нарын удирдлагаар боловсруулсан ажээ. МАХН, хятадын хувьсгалд ёс суртахуун, эд материалын талаар туслахын зэрэгцээгээр БНМАУ-д амьдарч байгаа хятадын харьяат нарын дотор хятадын хувьсгалыг дэмжих зорилготой олон нийтийн байгууллага үүсч, ажиллагаагаа эрчимжүүлэхэд нь бүх талаар туслаж байв. 1926 оны 8-р сард хятадын эв хамт залуучуудын анхдугаар салбар хурал Улаанбаатар хотод болж Эв хамт залуучуудын намд (эвлэлд Л.Ж.) элсэх зорилгын тухай гэх зэрэг асуудлууд хэлэлцсэн байна. Мөн сарын сүүлчээр хятад Эв хамт залуучуудын намын 2-р хурал хуралдаж, хятадын дотоод байдал, зохион байгуулалтын асуудал зэргийг хэлэлцжээ. Түүнд МАХН-ын ТХ-ны дарга Ц. Дамбадорж биеэр оролцож хэлсэн үгэндээ: «...танай олноор сайтар зүтгэн оролдохыг хичээх хэрэгтэй. Манай монголоос цаазлан хориглож, танай урагшлах замд саад болох нь үгүй болой»<sup>28</sup> гэж дэмжиж байгаагаа илэрхийлсэн байдаг.

ҮХЦ-ийн гол хүч 1926 оны 7-р сарын 9-нд Гуандун мужаас умар зүг гурван чиглэлээр давшив. ҮХЦ-ийн ангиуд дорнод хятадын мужуудыг чөлөөлөх дайны ажиллагааг 9-р сард эхлэв. Тэгэхэд цэргийн эрхтэн Сунь ЧуаньФаны цэрэг мөн л У Пэйфу шиг Англи Америкийн империалистуудын дэмжлэгээр эсэргүүцсэн боловч цохигдов. Фэн Юйсян 9-р сард ЗХУ-аас эгэж ирээд өөрийн цэргийн үндсэн хүчийг сэргээж, ҮХЦ-ийн хамт Мүгдэн Чжилийн цэргийн эрхтнүүдийн цэргийг бут цохихын төлөө цаашдын тэмцэлд идэвхтэй оролцов.

Фэн Юйсяны үндэсний цэрэг нь умартын аян дайн ийнхүү амжилттай явагдаж байхад 1926 оны 11-р сард Шэньси мужид ороод ҮХЦ-тай нийлэхийн тул мөн оны 12-р сард Хэнань муж руу давшжээ. ҮХЦ-ийн давшилт нь ажилчин, тариачны хувьсгалт тэмцэл өрнөх аятай нөхцөлийг бүрдүүлэв. Чөлөөлөгдсөн нутгуудад үйлдвэрчний эвлэл, тариачны холбоо болон олон нийтийн бусад ардчилсан байгууллагууд байгуулагдан ажиллаж байв. ХКН-ын гишүүдийн тоо олширч, ил ажиллах бололцоотой болов. Олон түмний дунд түүний нөлөө хүчтэй болж байв. Ингэж хятадын хувьсгал амжилт олж байгаа явдалд МАХН-ын ТХ баярлаж байгаагаа илэрхийлэн ГМД намын ТГХ-нд 1927 оны 3-р сарын 6-нд явуулсан бичигтээ: «Дундат Иргэн

улсын ардын намын хэрэг улам батжиж бэхжин элдэв хэрэг зорилгыг сайжруулан бүтээсээр буй учраас тус МАХН-аас ихэд баясан бишрэнэ. Иймийн тул үүнээс хойш МАХН ба ДИУ-ын Ардын Намын хэлхээ холбоог улам зузаатгаж мөнхүү ДИУ-ын Ардын Намын хэрэг зорилго туйлд хүрч ДИУ ба бүх дэлхийн түмэн ардын эрх чөлөөг бататган мандуулах буй за»<sup>29</sup> хэмээн итгэж байгаагаа илэрхийлээд бат дурсгал болгон улаан туг хүргүүлснээ дурьдсан байдаг.

1927 оны 3-р сарын 21-нд Шанхайн пролетари нар коммунистуудын удирдлагаар бослого гаргаж Шанхай хотыг цэргийн эрхтний захиргаанаас чөлөөлөв. 3-р сарын 22-нд Шанхайд ҮХЦ-ийн цэргүүд орж иржээ. Мөн түүний анги нэгтгэлүүд 3-р сарын 24-нд Нанжин хотыг чөлөөлсөн байна.

Империалист гүрнүүд хятадын хувьсгалын бүр эхнээс эхлэн харгис хүчнүүдийг дэмжиж байсан билээ. Үндэсний хувьсгал гүнзгийрэх тутам империалист гүрнүүдээс хятадын дотоод хэрэгт оролцох явдал улам гаарав. 1927 оны 3-р сарын 24-нд АНУ, Англи, Франц, Японы хөлөг онгоцнууд ҮХЦ-ийн чөлөөлсөн Нанжин хот руу халдав. Империалист гүрнүүд тус орны гол төвүүд рүү цэргийн хүчээ татаж эхлэв. 4-р сарын 11-нд Англи, АНУ, Франц, Япон, Итали улсууд Ухань дахь үндэсний засгийн газарт гадаадынхныг эсэргүүцэхгүй байх шаардлагыг тулгаж тавив.

Ажилчин тариачны хувьсгалт хөдөлгөөний далайц, империалист гүрнүүдийн шахалт нь хятадын үндэсний хөрөнгөтнүүдийг айлгаж хувьсгалаас хөндийрөхөд хүргэв. Империалистуудын заавар даалгавраар Чжан Цзолингийн цэргүүд 1927 оны 4-р сарын 6-нд Бээжин дэх зөвлөлтийн элчин сайдын яамны байранд дайран орж зөвлөлтийн нэлээд ажилтан ба тэнд байсан Ли Дачжао тэргүүтэй хятад коммунистуудыг баривчилж шоронд хорив. 4-р сарын 26-нд Ли Дачжао болон түүний нөхдийг цаазаар авсан юм.<sup>30</sup> Тяньцзин хот дахь зөвлөлтийн байгууллага руу бас халдав. Шанхай дахь олон улсын эзэмшлийн харгис цагдаа нар Зөвлөлтийн консулийн байрыг бүслэсэн байна. Чан Кайши империалистүүдтэй үгсэн хуйвалдаж тэдний дэмжлэгт түшиглэн 1927 оны 4-р сарын 12-нд Шанхай, Нанжин зэрэгт хувьсгалын эсэргүү эргэлт зохион байгуулж хийлгэв. Үүний дараагаар гоминьданы баруун жигүүрийн этгээдүүд Гуанчжоуд мөн эргэлт хийв. Чан Кайши 4-р сарын 18-нд Нанжинд «Үндэсний засгийн газар» гэгчийг эмхлэн байгуулав. Байдал ийм төвөгтэй болж байхад 4-5-р сард Уханьд ХКН-ын V их хурал болж ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Чэн Дусю болон түүний талынхны баруун оппортунист шугамыг буруушаагаад, ажилчин тариачны хувьсгалт хөдөлгөөнийг цаашид шийдэмгий хөгжүүлж, газрын шинэтгэл хийх тухай шийдвэр гаргасан боловч зэвсэгт тэмцлийг удирдах зэрэг чухал асуудлуудаар идэвхтэй арга хэмжээ авах шийдвэр гаргасангүй. Гэтэл Чэн Дусю, түүний талынхан их хурлын шийдвэрийг үл биелүүлж, өөрсдийн буун өгөгч шугамаа үргэлжлүүлж Коминтерны зөвлөлгөөг хэрэгсэхгүй байлаа. Гоминьданы зүүн жигүүрийнхний гуйвамтгай байдал, Чэн Дусюгийнхний буун өгөгч алдаа нь хувьсгалын хүчийг сулруулав.

Фэн Юйсян 6-р сарын 2-нд Чан Кайшигийн талд орохоо илэрхий мэдэгдэв. Ингэснээр Уханий засгийн газрын цэрэг умар зүг давшилтаа үргэлжлүүлэх бололцоогүй болов. Түүгээр ч үл барам Фэн Юйсян Уханий засгийн газрыг тараахыг тулган шаардах болсон байна. Хунань, Цзянси мужуудад хувьсгалын эсэргүүчүүд засгийн эрх булааж авав. 1927 оны 7-р сард Уханий хувьсгалт засгийн газар ба ГМДН-ын ТГХ дахь Ван Цзинвэй, түүний талынхан хувьсгалын эсрэг эргэлт зохион байгуулж, коммунистуудыг ГМДН-аас хөөж, ХКН-ыг хууль

бус гэж зарлахын хамт үйлдвэрчний эвлэл, тариачдын холбоог тараав. Олон коммунист ажилчин, тариачин, хувьсгалчдыг баривчилж хядав.

Ийнхүү умартын аян дайны ололт устгагдаж, хятадын үндэсний хувьсгал дарагдаж, тус орныг цуст харгислал нөмрөв. 1924 — 1927 оны хятадын хувьсгал дарагдсан шалтгаан нь юуны урьд ангиудын хүчний харьцаа хувьсгал ялахад тохиромжгүй байсан, ажилчин анги хийгээд ХКН харьцангуй дорой байсан, хувьсгалт тэмцлийн ид далайцтай өрнөлтийн үед хятадын хөрөнгөтнүүд урвасан зэрэг явдалд оршино. Энэ хувьсгалыг хятадын түүхэнд «дотоодын анхдугаар хувьсгалт дайн» гэж нэрлэдэг. Бодит шалтгааны улмаас энэ хувьсгал түр дарагдсан боловч хятадын эрх чөлөөний дараачийн тэмцэлд чухал дайчин сургамж болсон юм. ХКН тус орны улс төрийн амьдралын хүчирхэг хүчин зүйл, жинхэнэ олон түмний нам болж хувирав. 1923 онд империализмын эсрэг нэгдмэл фронт байгуулах шийдвэр батлахад хятадад дөнгөж 40-өөд коммунист байсан бол ХКН-ын V их хурлын үед тус нам эгнээндээ 57, 967 коммунисттай болоод байв. ХКН-ын удирдлагаар 35 мянган гишүүнтэй коммунист залуучуудын эвлэл, 2.9 сая хүнтэй үйлдвэрчний байгууллагууд ажиллаж байв. .

1927 оны намар хуралдсан МАХН-ын VI их хуралд тавьсан Төв Хорооны тайланд хятадын хувьсгал, түүнтэй МАХН хэрхэн харьцах тухай заахдаа: «Хятадын хувьсгал хэдийгээр энэ завсар түгшүүртэйн туйлд хүрч буй боловч даруйхан дахин хөгжиж өрнөх нь болзошгүй. Байдал учир иймийн тул манай нам хятадын жинхэнэ ардын үнэнч хувьсгалын этгээд лүгээ холбоо байгуулахыг хичээвэл зохих ба хөрөнгөтөн, мөн хуурамч хувьсгалт этгээдээс маш болгоомжлон сэрэмжлэвэл зохино» гэсэн байдаг.

<sup>1</sup> МАХН-ын программ, дүрэм. , УБ., 1980, 47-рт

<sup>2</sup> Мөн тэнд, 48 49-рт

<sup>3</sup> «МАХН ардын хувьсгалын ялалтын төлөө тэмцэлд баримт бичгийн эмхэтгэл» УБ., 1971, 89-рт

<sup>4</sup> «МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд» 1. УБ., 1966, 76-р тал

<sup>5</sup> Намын Түүхийн Төв Архив (НТТА) Ф No 1, т. 32, ХН-4

<sup>6</sup> НТА. Ф No—1, т.2., ХН—154

<sup>7</sup>НТА. ф No 1, т. 34, ХН-20

<sup>8</sup> Ө. Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүдтэй тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага, Тэргүүн дэвтэр. УБ., 1932. 82-83 тал

<sup>9</sup> НТА.Ф No — 1 Т-2, ХН— 139

<sup>10</sup> Мөн тэнд

<sup>11</sup> Мөн тэнд ф №—1, т—2. ХН-140

<sup>12</sup> НТТА, ф №--1, т.34, ХН — 22

<sup>13</sup> Мөн тэнд ф №--1, т-2. ХН— 176

<sup>14</sup> НТА Ф №-- 1, т. 34 ХН— 20

<sup>15</sup> Мөн тэнд

<sup>16</sup> Монгол хятадын харилцааны талаархи МАХН-ын интернационалч байр суурь» (өгүүллийн эмхэтгэл) УБ., 1984, 19—20-рт

<sup>17</sup> Цзян Боцзян, Шао Сюнчжэн. Ху Хуа. Чжунго лиши гайяо (Хятадын түүхийн найруулал) Бээжин, 1958, 8-р тал

<sup>18</sup> М.С. Капица. Советско-китайские отношения. М., 1958, стр. 132

<sup>19</sup> НТТА ф №— 1, т. 34, ХН— 6

<sup>20</sup> «Известия Улан-Батор хото» 4-VII — 1925 г.

<sup>21</sup> НТТА. Ф №—1, т. 34, ХН—34

<sup>22</sup> «Известия Улан-Батор хото» 1925. XI — 28

<sup>23</sup> Фэн Юйсян. Воды Шэнхо, (миний амьдрал) Чунцин. 1944, 71-р тал

<sup>24</sup> Мөн тэнд, 72-р тал

<sup>25</sup> Мөн тэнд 72-р талд

<sup>26</sup> Мөн тэнд 82-р талд

<sup>27</sup> Ху Хуа, Чжунго синь миньчжу чжуи гэминши. (Хятадын шинэ ардчилсан хувьсгалын түүх. ) Бэйцзин. 1951, 78—89-р тал

<sup>28</sup> НТТА, ф. № — 1, т. 34 ХН-34

<sup>29</sup> НТТА, ф №—1, т.3, ХН—14

<sup>30</sup> Новейшая история Китая. М., 1972, стр. 107